



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 48

Эрдэнэт

Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн
дуудлагын худалдааг зохион байгуулах журам,
гэрээний загвар батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 38-45 дугаар зүйл, Иргэний тухай хуулийн 197 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Худалдах, худалдан авах гэрээ”-ний загварыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д, мөрдөж ажиллахыг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 158 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА П.ПҮРЭВЛХАГВА